



ЭМС-ын A/513 тооот тушаалын  
дагуу ММЭнН-ийн тэргүүлэгчдийн  
2020.02.03 хурлаар хэлэлцэн батлав

**Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэшлийн зэрэг горилогчид  
тавигдах тусгай шаардлагын төсөл**

1. **Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэжлээр ахлах зэрэг горилогчдод тавигдах шалгуур:**
  - 1.1. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэжлээр 8 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан.
  - 1.2. ММЭнН-ийн үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох(баримтхавсаргах), идэвхи санаачилгатай байх
  - 1.3. Бүтээлийн жагсаалтанд ММЭнН-ийн "Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ" сэтгүүл (хамгийн багадаа 1) болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлж, 5-с доошгүй илтгэл (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.
  - 1.4. Эмчлэх тусlamж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх – зэргийншалгалтад орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх
  - 1.5. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд мэдээгүйжүүлгээр(эрчимт эмчилгээ) мэргэжилдээшлүүлэхсургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах
  - 1.6. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдсан байх – нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтад оролцсон гэрчилгээний хуулбарууд
  - 1.7. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх
  - 1.8. Мэргэжлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайлан – товч тоон үзүүлэлтээр
2. **Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэшилээр тэргүүлэх зэрэг горилогчдод тавигдах шалгуур:**
  - 2.1. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэшилийн ахлах зэрэг авснаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан
  - 2.2. ММЭнН-ийн үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох(баримтхавсаргах), идэвхи санаачилгатай байх
  - 2.3. Бүтээлийн жагсаалт гаргаж, өмнөх зэрэг хамгаалснаас хойш ММЭнН-ийн "Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ" сэтгүүлд (хамгийн багадаа 2) болон

бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлж, 5-с доошгүй илтгэл (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.

- 2.4. Эмчлэх тусламж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх – зэргийншалгалтад орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх
- 2.5. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд **мэдээгүйжүүлгээр** (эрчимт **эмчилгээ**) мэргэжил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах
- 2.6. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтад тогтмол хамрагдсан байх – нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтад оролцсон гэрчилгээний хуулбарууд
- 2.7. Шинээр суралцагч эмч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг зээмшүүлсэн, нийгэмлэгээс зохиосон сургалтын ажилд идэвхитэй оролцсон байх
- 2.8. Залуу эмч, сувилагчийн сургалтад оролцож хичээл заадаг – хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах
- 2.9. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх
- 2.10. Англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийг нотлох баримтыг (үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал) хавсаргана
- 2.11. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан – товч тоон үзүүлэлтээр
3. **Мэдээгүйжүүлэг** эрчимт **эмчилгээний** мэргэжлээр зөвлөх зэрэг горилогчдод тавигдах шалгуур:
  - 3.1. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэжлийн тэргүүлэх зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш, үндсэн мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан
  - 3.2. Сум дундын эмнэлэгт мэдээгүйжүүлгийн эмчээр тогтвортой суурьшилтай, тасралтгүй 20 ба түүнээс дээш жил ажилласан, тусгай шалгуур хангасан бол зөвлөх зэрэг горилж болно.
  - 3.3. АШУ эсвэл АҮ-ны магистр, клиникийн профессор (хоёулаа байх) цолтой байх
  - 3.4. ММЭнН-ийн үлгэр жишээч гишүүн байх, үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, нийгэмлэгээс зохиосон сургалтын ажилд идэвхтэй оролцсон байх
  - 3.5. Өмнөх зэрэг хамгаалснаас хойших Бүтээлийн жагсаалт гаргах. Үүнд:

- 3.5.1. ММЭНН-ийн "Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ" сэтгүүл (хамгийн багадаа 3) болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 5-аас доошгүй өгүүлэл (онолын тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлсэн,
- 3.5.2. 8-с доошгүй илтгэл (онол практикийн хуралд) хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.
- 3.5.3. Өөрөө бичиж хэвлүүлсэн ном болон хамтран бүтээсэн номын тоо 2-оос доошгүй байх
- 3.5.4. Гаргаж баталгаажуулсан оношилгоо, эмчилгээний удирдамжийн тоо 2-оос доошгүй
- 3.5.5. Зохиогчийн эрх, ашигтай загвар, оновчтой саналын гэрчилгээний аль нэгийг авсан байх
- 3.5.6. Эмнэлзүйн практикт бодитоор нэвтрүүлж үр дүнгээ өгсөн шинэ арга 2-оос доошгүй байх
- 3.6. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, энд дурдагдсан тусгай шалгуурыг ханган биелүүлж, хамт олондоо хүндлэгдсэн үлгэр жишээчээр ажиллаж байгаа, зөвлөх зэргийн шалгалтад орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх
- 3.7. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд **мэдээгүйжүүлгээр** (эрчимт эмчилгээ) мэргэжил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах
- 3.8. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдсан байх – нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтад оролцсоны гэрчилгээний хуулбарууд
- 3.9. Шинээр суралцсан эмч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг зээмшүүлсэн, залуу эмч, сувилагчийн сургалтанд оролцож хичээл заадаг – хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах
- 3.10. Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх
- 3.11. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх
- 3.12. Англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийг нотлох баримтыг (үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал) хавсаргана
- 3.13. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан – товч тоон үзүүлэлтээргаргах